

**XX ЗУУНЫ ЭХЭН ҮЕИЙН ЧИН УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬТ ЗАСАГЛАЛД  
ШИЛЖИХ ҮЕИЙГ ИЛТГЭСЭН НЭГЭН МОНГОЛ СУРВАЛЖ БИЧИГ<sup>1</sup>**

ОЮУНДАЛАЙ

**Товч агуулга:** Тус өгүүлэлд Чин улсын сүүлч “Шинэ засаг”-ийн бодлого хэрэгжих хугацаанд 1910 оны 9 сард Засагт тус хийх яам гэх байгууллага нийслэл Бээжин хотноо анх байгуулагдан, Халх Монголын ван, гүн нарын дотроос Пунцагцэрэн гэдэг ванг төлөөлөгчийн хувиар тус яамны хэрэг хэлэлцэгч түшмэлээр томилсонд тэрээр Бээжин хотноо алба гүйцэтгэн Засагт тус хийх яамны хуралдаанд оролцох үедээ Халхын Их Хүрээнд суух Богд гэгээнтэн болон түүний гэргий Дондогдулам нараас удаа дараа захидал хүлээн авч байсныг амбан сайдын тэмдэглэлд дурдсан баримтад тулгуурлан Чин улсын сүүлч “Шинэ засаг”-ийн бодлого нь Монгол орны эд агуурсыг өргөн хэмжээгээр цөлбөн дээрэмдэх болсон мөн чанарыг илчлэн, монголчууд Чин улсаас тусгаарлан салах арга замыг эрж сүвэгчлэхээр болсон гэдгийг өгүүлжээ.

**Түлхүүр үг:** Засагт тус хийх яам; Пунцагцэрэн ван; мөн чанар;

**Удиртгал**

Монгол Улсын Үндэсний Номын сангийн сан хөмрөгт “Дархан чин ван Пунцагцэрэн Засагт тус хийх яамнаа одоходоо инагш чинагш харилцсан тэмдэглэл” гэж эх сурвалж хадгалагдаж байна. Тус сурвалжийг одоо хир хэвлэн нийтэлж гаргаагүй байна. Гэхдээ зарим судлаачид түүнийг тодорхой хэмжээгээр ашиглаж байжээ.

Энэхүү түүхэн эх сурвалжийг анхлан түүхч Л. Жамсран “Монголчуудын сэргэн мандалтын эхэн” (УБ., 1991, тал 11) бүтээлдээ Чин улсын улс төрийн шинэтгэлийн талаар судлан бичихдээ уг сурвалжаас Хэлэлцэгч түшмэлүүдийн хуралдааны тухайд эш татан ашигласан байна. Түүний дараа Түүхч Ж. Урангуа

<sup>1</sup> Тус өгүүлэл нь Өвөр Монголын Үндэстний Их Сургуулийн “Монгол үндэстний товч түүх”-ийн хичээлийг хөгжүүлэх төсөл болон Монгол Судлалын Дээд Сургуулийн “Монгол үндэстний соёлын түүх”-ийн заан сургах төслийн санхүүжилтийг хүртэв.

БНХАУ-ын Бээжин хотноо 2012 онд Төвийн Үндэстний Их Сургууль дээр болсон Сурвалж судлалын олон улсын хурал дээр “Хэвт ёсны хоёрдугаар оны найман сарын арван хоёрноос эхлэн Нийслэл хотын газар албан бичиг зүйлийг сийрүүлсэн данс. Дархан чин ван Пунцагцэрэн Засагт тус хийх яамнаа одоодоо инагш чинагш харилцсан тухай тэмдэглэл” гэсэн илтгэл тавьж уг сурвалжийг эх бичиг талаас нь судлан үзсэнээ илтгэжээ. Дараа нь тэр бээр уг илтгэлээ дэлгэрүүлэн судалгааны өгүүлэл болгон Япон улсын Токио хотноо “*Quaestiones Mongolorum Dipputatae*” сэтгүүлийн 2013 оны IX дугаарт хэвлүүлжээ. Чингэхдээ Засагт тус хийх яамны хуралдаан гэдэг нь чухам ямар зүйл байсан, монголчуудад тустай зүйл хийх байгууллага байсан уу, үгүй юу гэдэгт гол анхаарлаа хандуулжээ. Энэ хоёр түүхчээс өөр тус гар бичмэл эх сурвалжийг ашигласан болон судалсан хүн одоогоор байхгүй байна.

Миний биечлэн судлан үзсэн энэхүү эх сурвалж нь Чингийн төрөөс өөрийн сул дорой байдлыг засаж залруулахын тулд хэрэгжүүлж байсан Шинэ засгийн бодлогын нэгэн чухал асуудлыг нээн харуулахад чухал ач холбогдолтой болно. Хятад орон даяар Үндсэн хуульт байгуулалд шилжихийг Чингийн төрөөс шаардаж байсан тэр үед улс төрийн салбарт хийх шинэтгэлийн бодлогын нэг хэсэг болсон Чингийн парламент буюу Засагт тус хийх яамны хуралдаан хэрхэн эхэлж, явагдсан хийгээд тус хуралдаанд Ар, Өвөр Монголын ноёдын оролцоо ямар байсныг бид энэ эх сурвалжаас харж болж байна.

Засагт тус хийх яамны хуралдаанд хэлэлцүүлэхээр ямар нэгэн асуудалд оруулахад 30 хүн нийлж байж, асуудал дэвшүүлэх эрхтэй болно. Мөн хэлэлцэх үед 2/3 хувийн санал авч байж асуудал батлагдах дүрэмтэй байжээ. Гэтэл Ар, Өвөр Монгол хошуудын ноёд 10 гаруйхан хуралд ирсэн учир, монголчууд Шинэ засгийн бодлогыг эсэргүүцсэн санал оруулах боломжгүй байжээ. Тиймээс Засагт тус хийх яамны хуралдаан монголчуудад ашиг тус авчрахгүй гэдэг нь ойлгомжтой болсон бөгөөд Пунцагцэрэн ч хуралдааныг хаян гэдрэг буцсан байна.

Тус тэмдэглэлд Ар Монголоос Хүрээний сайд Пунцагцэрэн, Сэцэн хан аймгийн засаг Доржпалам нар албан ёсны төлөөлөгчөөр явжээ. Харин манжийн эфү болох Ширнэндамдин, Бээжинд суух Наянт ван нар Пунцагцэрэн болон Доржпаламд их тус болж байжээ. Харин энэ сурвалжаас Дотоод Монголоос чухам хэн хэн гэдэг ноёд очсоныг мэдэх боломжгүй байна. Гэхдээ Пунцагцэрэн бэйс Ар, Өвөр Монголын бид хэд 10 гаруй хүн гэж тэмдэглэснээс үзэхэд өвөр хошуудаас ноёд очсон нь тодорхой байна. Энэ үед өвөр хошуудын ноёд ч гэсэн

Шинэ засгийн бодлогын хүрээнд олон хятад тариачдыг нутаг орон руу нь түрэн оруулж байсанд ихээхэн дургүй байсан нь ойлгомжтой.

Монголын шашин шашны тэргүүн VIII Богд Жибзундамба хутагт хоёр асуудалд ихээхэн санаа зовниж байсан нь түүний бичсэн бичиг захидлуудаас тодорхой байна. Нэгд: 1910 онд Их Хүрээнд лам нар хятад пүүсийн хүмүүстэй маргалдан зодолдож, улмаар энэ нь олон түмний эмх замбараагүй байдалд хүргэсэн учир Их Шавийн шанзудба Бадамдоржийг албан тушаалаас нь огцруулсан байв. Тиймээс шанзудбыг эргүүлэн албан тушаалд нь томилуулах асуудлыг төлөөлөгчдийг хөөцөлд гэжээ. Өөр нэг асуудал бол Богд гэгээний мэлмий муу харах болсон тул сайн эмч олж эм залах, мөн Дондогдулам зурхайч хүнээр 10 зүйлийн юм мэргэлүүлжээ. Эдгээр нь цаашид нарийвчлан судлах шаардлагатай, хэрэгцээтэй мэт.

Монголын төлөөлөгчдийн энэхүү аян замын тэмдэглэл нь XX зууны эхэн үеийн Монголын түүхэнд холбогдох чухал сурвалж бөгөөд үүнийг орчин цагийн кирилл үсэгт буулган хэвлүүлэн гаргавал олон нийтийн хүртээл болох болно.


### **1. Эх сурвалжийн тухай**

Монгол Улсад Чин улсын сүүл “Шинэ засаг”-ийн бодлоготой холбогдсон бичиг баримтын нэгэн олдвор, Монгол Улсын Үндэсний Төв номын санд хадгалагдаж байгаа гар бичмэл (хадгаламжийн дугаар нь 1393\96) болно. Уг бичиг олсон дээс үдээртэй, Чин улсын үеийн албаны данс бичигт байнга хэрэглэж байсан нугалбар цаастай, 12 мөрийн улаан өнгийн шугамт шар цаасан дээр бичигдсэн, хөх өнгийн гадартай. Гарчиг нь “Хэвт ёсны үеийн хоёрдугаар он, найман сарын арван хоёроос эхлэн нийслэл хотны газар аливаа бичиг зүйлийг сийрүүлсэн данс”<sup>2</sup> гэх хоёр мөр үсгийн ард жижиг үсгээр хоёр мөрөөр “Дархан Ван Пунцагцэрэн Бээжингийн Засаг дор тус хийх яамны хэлэлцэх түшмэлээр одохуй дор инагш чинагш харилцсан ба [үйл?]-ийн тэмдэглэл” гэж бичсэн. Хойшид “данс дэвтэр” гэж товчилно. Тус данс дэвтрийн гадар нь багавтар урагдан сэмсэрсэн болохоор нэг үг нь уншигдахгүй болжээ. Барагцаалбал “үйл” гэсэн үг бололтой. Тус данс дэвтэр нь нийт 39 хуудастай. 1-14 дүгээр хуудас дуустал нийт 15 хувь харилцааны бичиг байна.

Агуулга нь голдуу Засагт тус хийх яамны Хэрэг хэлэлцэгч түшмэлээр шинэхэн томилогдсон Хүрээний монгол сайд Пунцагцэрэн Хэвт ёсны хоёрдугаар

<sup>2</sup> Монгол Улсын Үндэсний Төв Номын Санд хадгалагдаж буй гар бичмэл (хадгаламжийн дугаар нь 1393\96)

оны найман сарын шинийн нэгнээс Хүрээнээс өртөөлөн мордож, арван хоёрны өдөр нийслэлд ирж Гадаад Монголын Төрийг Засах Явдлын Яаманд айлтгал дэвшүүлэн, дээдийн амгаланг (хааны амгаланг) эрэхийг хүсэмжилсэн агуулгаар эхэлсэн. Залгаад Пунцагцэрэнгээс тушаал гүйцэтгэж байх хугацаандаа хүнсний мөнгө, ам хүнс олгож болох, үл болох тухай Гадаад Монголын Төрийг Засах Явдлын Яамаар дамжин харилцаж, өөрийн олох ёстой ам хүнсээ дагалт зарцаар тоо ёсоор хүлээн авсан тухай батлах бичиг бүхий 7 удаа нааш цааш харилцсан бичгүүд бий. Бас “Ий Хэ Цан” хэмээх Буяндалайн пүүсээс хар мөнгө 2000 ланг хүүтэй зээлсэн тэмдэгт бичиг олгосон агуулгаас бусад 6 удаагийн бичиг нь Пунцагцэрэн ус шороо таарахгүй байна гэх буюу газрын чийг, чулуун нүүрсний хороор толгой өвдөж байна гэж тушаалаа огцрон нутагтаа буцахыг санаачлан Гадаад Монголын Төрийг Засах Явдлын Яамаар дамжуулан Засагт тус хийх яамнаас зөвшөөрөл олохыг гуйчлан харилцсан бичиг баримт байж, эцсийн удаа нь Хэвт ёсны хоёрдугаар оны 11 дүгээр сарын шинийн 4-ний өдөр, Засагт тус хийх яамнаас түүний хоёр ч удаа өвчинтэй гэж мэдүүлсэнд хариу зарлиг бууж, нутаг буцахыг зөвшөөрсөн боловч түүний оронд заавал харьяат аймгийнхаа ван, гүнгээс нэрийг хүргүүлж, орон тоог нөхөж мэдүүлэхийг шаардсан байдаг.

Тусдансдэвтрийн 15-39 дүгээрхуудасныагуулганьүндсэндээПунцагцэрэнгээс Богд гэгээнтэн болон түүний Гэргий Дондогдуламтай 13 удаа харилцсан захидал захиасаас гадна бас  (Да Гүн Яе - эшлэгчээс) хэмээх ахтайгаа 4 удаагийн харилцсан захиа бичиг байхын дотор нэгэн битүүмж манж хэлээр бичсэн захиа байна. Пунцагцэрэнгээс эдгээр хүмүүстэй харилцахдаа Нийслэл хотноо болж байх аливаа чимээ сураг зэргийг тоочин бичсэн нь тухайн цаг үеийн нөхцөл байдлыг таньж мэдэхэд дөхөмтэй. Мөн Шинэ засгийн хугацаанд байгуулагдсан Засагт тус хийх яам хэрхэн эрхлэн явагдуулж байгаа байдлыг нарийн тодорхой мэдүүлэн өгүүлсэн байна. Тиймээс уг сурвалж нь Чингийн төрөөс Үндсэн хуульт байгуулалд шилжихийн тулд өмнө нь авч хэрэгжүүлсэн арга хэмжээнүүдийг үр дүнд ямар байгууллагаа байгуулагдсан, түүний хуралдааны дэг журам зэргийг таньж мэдэхэд мөн ач холбогдолтой.

## **2. Дархан ван Пунцагцэрэнгийн тухай танилцуулах нь**

Тус данс дэвтэрт илэрсэн дархан ван Пунцагцэрэнгийн тухай түүний Гадаад Монголын Төрийг Засах Явдлын Яамтай харилцсан бичгээс мэдэж болно. Эдгээр бичигт “Засагт тус хийх яамны Хэрэг хэлэлцэгч түшмэл, Хүрээний монгол сайд, Цзян

Жи мэнд явагч Халхын Түшээт хан аймгийн засаг хошууны”<sup>3</sup> гэж өгүүлсэн байдаг. Тэрээр шинэ засгийн бодлогын хугацаанд Засагт тус хийх яам анх байгуулагдахад Хүрээний монгол сайдын төлөөлөгчийн хувиар Нийслэл Бээжинд ирсэн байна. Пунцагцэрэн бол Халхын Түшээт хан аймгийн Түшээт ваны хошууны засаг ноён.

Түүний гарал Даян хааны үр Гэрсэнз Жалайр хунтайжийн хойчис, Түшээт хан Чахундорж болно. Чахундорж Энх амгалангийн гучдугаар онд (1691) Долнуурын чуулганд Чин улсад дагаар орж, өргөмжлөл хүртсэн, Чахундоржийн ахмад хөвгүүн Галдандорж анх жүн ван өргөмжлөгдөн удалгүй нас барсанд Галдандоржийн хөвгүүн Дондовдорж Энх амгалангийн гучин есдүгээр онд (1700) чин вангийн хэргэм хүртэн үе улиран залгамжлав. Аравдугаар удаа залгамжилсан нь энэ Пунцагцэрэн байж, Намжилдондовын ахмад хөвгүүн, Бадаргуулт төрийн аравдугаар онд (1884) засаг хошууны бэйс хэрхэм залгамжлав. Бадаргуулт Төрийн хорин нэгдүгээр онд (1895) Жибзундамба хутагтын түлэгдсэн сүмийг шинэтгэн засах зэрэг үйлд тусалсан учир гурван дэсийн зэрэг нэмжээ. Бадаргуулт Төрийн хорин тавдугаар онд (1899) Хүрээнд суух хэрэг шийтгэгч сайд болжээ<sup>4</sup>. Дараа бас Түшээт ханы жанжны тушаалд явсан зүүн гарын цэргийг захирах ноёдын нэрсийн жагсаалтад дархан ван Пунцагцэрэн 1893-1899 оны хооронд байсан<sup>5</sup> гэж тэмдэглэж байсан ба аймгийн чуулган дараагийн тушаалд явсан ноёдын нэрсийн жагсаалтад дархан цэн ван Пунцагцэрэн 1914-1921 онд тушаалд байсан<sup>6</sup> гэж тус тус тэмдэглэгджээ.

Монгол улс тусгаар тогтнолоо тунхаглан зарлан, Богд гэгээнтнийг хаан өргөмжлөн эрдэнийн сууринд залсны учир зарлигаар хишиг тархаахад нь үе улиран залгамжлах чин вангийн дархан цол хүртжээ. Үүнээс бид Пунцагцэрэн ван бол алтан урагтны хойчис байж, Хүрээний засгийн албан тушаалд байсан, бурхны шашинд сүжиг бишрэл ихтэй, Богд хутагт Жибзундамбын үнэнч сүсэгтэн байсан гэдгийг мэдэж болно.

### **3. Засагт тус хийх яамны тухай Пунцагцэрэн вангийн бодол**

Чин улс нь “шинэ засаг”-ийн бодлогоо хэрэгжүүлэх явцдаа Англи буюу Японы үндсэн хуульт хаант ёсны байгууламжийг мөрдөн дуурайж, 1910 оны 9 сард Засагт тус хийх яам гэгчийг анх эхлэн байгуулсан байдаг. Пунцагцэрэнгээс

<sup>3</sup> Монгол Улсын Үндэсний Төв Номын Санд хадгалагдаж буй гар бичмэл (хадгаламжийн дугаар нь 1393\96) данс дэвтрийн 1.

<sup>4</sup> *Галсангийн Навааннамжилын бүтээлийн дээжис*, Улаанбаатар, 2011, 18-20.

<sup>5</sup> Сономдагва, Ц. *Монгол Улсын засаг захиргааны зохион байгуулалтын өөрчлөлт шинэчлэлт (1691-1997)*, Улаанбаатар, 1998, 8.

<sup>6</sup> Сономдагва, Ц. *Монгол Улсын засаг захиргааны зохион байгуулалтын өөрчлөлт шинэчлэлт (1691-1997)*, Улаанбаатар, 1998, 10.

Их хүрээний монгол сайдын төлөөлөгчийн хувиар томилогдон Засагт тус хийх яамны хэрэг хэлэлцэгч түшмэлээр оролцсоны дараа Богд гэгээнтэнд захидал бичиж Засагт тус хийх яамны хэрэг хэлэлцүүлгийн бүхий л болж өнгөрсөн явцыг алдалгүй мэдүүлж байсан байна.

Пунцагцэрэн ван найман сарын нэгний өдөр Хүрээнээс мордож, есний өдөр Чуулалт хаалга хүрч, арван нэгний өдөр Чуулалт хаалганаас галт тэргээр Бээжин хүрч, арван дөрөвний өдөр Эзний амгаланг эрж, улсыг захирсан Төрийг эрхэлсэн ванд бараалхан тус вангийн дүү Туу бэйл гэгч гадаадын олон улсаар яваад гээгээ хяргаж, орос хувцас өмсөж, саяхан буцаж ирээд ах вандаа гадаад улсын дүрэм маш сайн хэмээн ухуулан магтсан учраас цэргийн түшмэл ба олон цэргийг цөм гээгийг нь хяргуулж, орос хувцас өмсгөмүй, бичгийн түшмэд ба олон иргэд хэчнээн удах ажээ гэж олон хүмүүс хэлэлцэж байгааг Богдод мэдүүлж байсан мөртөө Засагт тус хийх яам нээсний хойно ямар зүйлийн хэрэг хэлэлцэхийг мэдэхгүй байна гэж захидал илгээсэн байна.<sup>7</sup> Үүнээс үзэхэд Засагт тус хийх яамны хуралдааны талаар дэлгэрэнгүй мэдээлэл урьдчилан аваагүй байсан бололтой. Ингээд, Хэвт ёсны хоёрдугаар оны есөн сарын шинийн хоёрын өдрийн захиа бичгийг сийрүүлэн үзье.

“Засагт тус хийх яамны хэрэг хэлэлцэгч түшмэд бүгд хоёр зуугаад хүмүүн найман сарын хоринд яамандаа хуралдаж, олон түшмэдийг шаваа татаж зургаан анги болгон хувааж, анги бүр гучин хоёр гурван хүмүүн нэгэн байшинд хуралдах болгосонд ...энэ есөн сарийн шинийн нэгнээс эхлэн чухам хэрэг хэлэлцэх цаад зургаан ангийн түшмэд бүгдээр нэгэн байшинд хуралдан зэрэг дэсээр дараалан суугаад тус яамны тэргүүн дараа суудлаасаа босож тийм хэргийг ийнхүү шийтгэсүгэй хэмээмүй хэмээн асуухад цаад олон түшмэдээс зөвшөөрөх хүмүүн цагаан цаасанд, үл зөвшөөрөх хүмүүн хөх цаасанд тус тус нэрээ бичиж хайрцагт агуулаад алин нь үлэмж болбоос түүнийг нь дагаж төлөвлөн тогтоох ба хэлэлцэх хэрэг нь улсыг захирсан төрийг эрхэлсэн вангаас зарлан ухуулсан ба цэргийн тухайн сайдууд, олон журган, олон мужийн газраас тушаасан лавласныг хэлэлцэн төлөвлөж, айлтган тогтоолгох зэргээр олон зүйлийн дүрэм хэмжээ тогтоон айлтгасныг зарлиг ёсоор болгосон хэмээх ...”<sup>8</sup>

Тус захидлаас бид Засагт тус хийх яам нь нийт хоёр зуу орчмын хүмүүсээр бүрэлдэж, зургаан дугуйлан хуваан гуч гаруй хүмүүн нэг дугуйлан болж, хэрэг учир ярилцаж зөвлөлдсөний дараа дахин нийтээрээ нэгэн гэрт цугларч, зөвшөөрөх

<sup>7</sup> Монгол Улсын Үндэсний Төв Номын Санд хадгалагдаж буй гар бичмэл (хадгаламжийн дугаар нь 1393\96) данс дэвтрийн 15.

<sup>8</sup> Монгол Улсын Үндэсний Төв Номын Санд хадгалагдаж буй гар бичмэл (хадгаламжийн дугаар нь 1393\96) данс дэвтрийн 18.

нь цагаан цаасанд, зөвшөөрөхгүй нь хөх өнгийн цаасанд тус бүр нэрээ бичиж, хайрцагт хийж, цөөнх нь олонх тооны хүмүүсийн санааг дагах дүрэмтэй байсан гэдгийг мэдэж болно.

Засагт тус хийх яамны дүрэмд хэлэлцэгч түшмэдээс ямар нэгэн хэргийг заан гаргаж, хэлэлцүүлэх буюу залруулах гэвэл заавал гучин хүмүүнээс дээш зөвшөөрөн нэр холбоолсон бичиг өргөвөл сая Засагт тус хийх яамнаас авч хэлэлцээд бүх хоёр зуу орчим түшмэдийн гуравны хоёроос дээш хүмүүс нь зөвшөөрвөл сая хүчинтэй болох тогтоолтой байсан мөртөө нэгэн зүйлийн хэрэгт хоёр дахин мэдүүлж болохгүй гэсэн тогтоолтой байсан байна.<sup>9</sup> Иймээс Пунцагцэрэн ван Чин улсын шинэ засгийн бодлогын Монгол оронд хэрэгжихийн мөн чанар нь Монгол орны эд баялгийг улам нэг хэмжээгээр цөлбөн дээрэмдэх болсон гэдгийг танин мэдсэн ч төлөөлөгчөөр оролцсон хэдэн монгол ван гүнгийн санаагаар хориглон зогсоож чадашгүй болсон нь илэрхий харагдана.

Засагт тус хийх яамны дүрэм тогтоолын эмзэг буурай талыг Пунцагцэрэн вангаас хурц соргогоор олж таньж байсан мөртөө, удаан жилээр засагт явсан хүмүүний хашир ухаантай байсан гэдгийг түүний Богд гэгээнтэй харьцаж байсан захидлаас харагдана. Тэрээр Засагт тус хийх яамны хэрэг хэлэлцэгч гишүүдийн гуравны хоёроос дээш хүмүүн нь зөвшөөрсөн байх хэрэгтэй гэх зарчмыг Богдод мэдүүлэх зэргээр тус яаманд хэлэлцэгч түшмэлээр сонгогдон орсон монгол ноёд нь бүгд арваад хүмүүн байж, түүний дотор Халхын ноёд нь хоёр гуравхан байдгийг залруулахыг эрж мэдүүлэх дүрэмд хүмүүний тоо нь огт хүрэлцэхгүйн дээр хятад болбоос язгуураас газар тариа тарихад маш дуртай, тус яамны хэлэлцэгч түшмэлийн аравны найм, ес нь цөм хятад түшмэд учраас бидний хэдхэн монгол хүмүүний хэлснийг зүйтэй хэмээн зөвшөөрч журганд шийтгүүлэхээр заан гаргаж айлтган хэлэлцүүлсэн хэргийг явцгүй болгох нь бараг гэж тодруулан өгүүлсэн байдаг.<sup>10</sup> Иймээс тэр Засагт тус хийх яам нь монголчуудад ашиггүй гэдгийг үзэж таниад эртхэн нутагтаа буцаж олон монголчуудаараа зөвлөлцөн өөр арга зам эрж сүвэгчлэх болсон нь зайлшгүй байжээ. Ингээд ус, шороо таарахгүй өвчинтэй байна<sup>11</sup> гэж шалтгаалан нутаг руугаа буцахаар Гадаад монголын төрийг засах явдлын яаманд хүсэлт дэвшүүлж байжээ.

<sup>9</sup> Монгол Улсын Үндэсний Төв Номын Санд хадгалагдаж буй гар бичмэл (хадгаламжийн дугаар нь 1393\96) данс дэвтрийн 22-23.

<sup>10</sup> Монгол Улсын Үндэсний Төв Номын Санд хадгалагдаж буй гар бичмэл (хадгаламжийн дугаар нь 1393\96) данс дэвтрийн 23.

<sup>11</sup> Монгол Улсын Үндэсний Төв Номын Санд хадгалагдаж буй гар бичмэл (хадгаламжийн дугаар нь 1393\96) данс дэвтрийн 7.



#### 4. Шинэ засгийн бодлого нь Монгол орны ашиг тусыг хохируулсан нь

Чин улс нь Шинэ засгийн бодлогоо хэрэгжүүлэх явцдаа Монгол орноос ашиг тус олж, аж ахуй эдийн засгийнхаа хоцрогдлоо шийдвэрлэхийг онцлон хичээж байжээ. Засагт тус хийх яамнаа Монгол оронд хятад иргэдийн боомт давж, газар тариа хагалбарлах, монгол эхнэр авах, монголчуудын хятад газраас шашин залж, хятад бичиг заалгаж, хятад нэр авах мэтийн зүйлсийг цаазалж байсан төрийн бодлогоо бүрмөсөн өөрчлөхийг хэлэлцүүлсэн байна.<sup>12</sup> Чин улсын ноёд түшмэдээс хятад иргэдийн монгол газар атар хагалбарлан оршин суухыг зөвшөөрөх, Монгол газрын нөөц баялгийг хэрхэн бүтэмжтэй ашиглан ашиг орлого олохыг онцлон анхаарч байсан байна. Тус яаманд төлөөлөгчөөр суусан монгол ван гүн нарын эсэргүүцлийг хайхралгүй, манж түшмэлийг нууцаар томилон Хүрээнд ирүүлж, нутгийн гаралт ямар зүйлс байгааг нарийвчлан байцаасан байдаг.<sup>13</sup>

Пунцагцэрэн вангаас Богд гэгээнтэнд бичсэн нэгэн удаагийн захидалдаа “Монгол журган (Гадаад Монголын төрийг засах явдлын яам)-аас монгол аймаг, хошуунд малын бэлчээр зохистой үлдээж, үлдсэн газарт нь монголчууд өөрсдөө тариа хагалбарлах буюу, эсхүл монголчуудаас иргэдэд газрыг хөлслөн өгч тариа тариалах болбоос, цөм дураар явуулбал зохих ба уурхайн хэрэг, мод, загас, гөрөөс, эвэр, яс, арьс, ноос зэргийг хэрхэн шийтгүүлэхийг Засагт тус хийх яамнаа тушаал хэлэлцүүлэхээр айлтгаад тушаасан ажээ”<sup>14</sup> гэж захидалдаа бичсэн байжээ. Үүнээс Чин улс нь Шинэ засгийн бодлогоо хэрэгжүүлэхдээ Монгол орны баялгийг чухалчлан байцаан бүртгэж, монгол газраас ашиг орлого олохыг санаачлан байсан нь илхэн байна.

Пунцагцэрэн вангаас Засагт тус хийх яамны Монгол орон дахь хорио цаазат төрийн бодлогоо хувируулах нь манай монголчуудын аж ахуйд харшлалтай зүйл байгааг соргогоор таньж, Засагт тус хийх яаманд дахин хэлэлцэн залруулахыг санавч, Засагт тус хийх яамны тогтоолд нэгэнт нэгэн зүйлийн хэрэгт хоёр удаа дахин гуйн мэдүүлж үл болох тогтоол байх учраас даруйхан нутагтаа буцсаны хойно олноороо зөвлөлдөн Монголд харшлалтай зүйлийг тодорхойлон гаргаж, хамтаар зөвлөлдөх санаагаа Богд гэгээнтэнд мэдүүлж байжээ.<sup>15</sup> Дээрх байдлаас

<sup>12</sup> Монгол Улсын Үндэсний Төв Номын Санд хадгалагдаж буй гар бичмэл (хадгаламжийн дугаар нь 1393\96) данс дэвтрийн 19.

<sup>13</sup> Монгол Улсын Үндэсний Төв Номын Санд хадгалагдаж буй гар бичмэл (хадгаламжийн дугаар нь 1393\96) данс дэвтрийн 24.

<sup>14</sup> Монгол Улсын Үндэсний Төв Номын Санд хадгалагдаж буй гар бичмэл (хадгаламжийн дугаар нь 1393\96) данс дэвтрийн 22.

<sup>15</sup> Монгол Улсын Үндэсний Төв Номын Санд хадгалагдаж буй гар бичмэл (хадгаламжийн дугаар нь 1393\96) данс дэвтрийн 23.



үзэхэд Чин улсын Шинэ засгийн бодлогоор Монгол орныг нээн ашиглах тухай Засагт тус хийх яамны зөвлөгөөн хэлэлцүүлэг нь монгол ван гүн нарын төдийгүй нийт монголчуудын ашиг тусыг хохируулж байжээ.

### **5. Пунцагцэрэн ба Богд Жибзундамба хутагтын харилцаа**

Тус данс дэвтрээс бид Пунцагцэрэн бэйс бурхны шашинд маш сүжиг бишрэлтэй байж, Богд Жибзундамба хутагтын үнэнч шавь байсан гэдгийг түүний харилцаж байсан захидлаас харж болно. Тэрээр олон удаа захидал бичихдээ удаа дараалан “өчүүхэн шавь хичээнгүйлэн, Очирдара Богд лам эрдэнэ сэцэн ноён таны алтан өлмийн доор наминчлан сөгдөж, түмэн амгаланг айлтган мөргөмүй”<sup>16</sup> гэж маш хүндэтгэлтэйгээр эхэлсэн байна. Хэрэв бид энэхүү бичлэгийн тигийг тухайн үеийн хүмүүсийн Богд гэгээнд бичдэг хэв намба гэж ойлговол, бид тус данс дэвтрээс ондоо газарт олон жишээ баримтыг дурдаж болно. Тэрээр Бээжинд байх хугацаандаа нүд эмнэн засахдаа сайн дал гарсан алдартай сайн отчийг сураглан олж, Богдын хараа муудсан шалтгааныг асууж, “Түн Рэн Таан” эмийн пүүсээс тусгай эм найруулан Богдод хүргэж явуулсан байдаг.<sup>17</sup> Үүнээс түүний Богдод хэчнээн үнэнч байсныг мэдэж болно. Банчин богд, Далай ламын хаа явж байгааг сураглан, Чин улсын засгийн газарт өвчний шалтаг хэлж Засагт тус хийх яамны хэрэг хэлэлцэгч түшмэлийн тушаалаасаа эртхэн огцорч, гэр орондоо амар мэнд буцахыг наминчлан даатгаж байжээ.<sup>18</sup> Үүнээс бид Пунцагцэрэн вангийн бурхны шашинд сүжиг бишрэл ихтэй байсан, Богд гэгээнтний үнэнч сүсэгтэн нь байсан гэдэгт эргэлзэхгүй байна. Монгол Улсын Их Сургуулийн түүхч Хэрээд Ж.Урангуа “Чин гүрний Засагт тус хийх яамны хуралдаанд монгол ноёд оролцсон нь”<sup>19</sup> гэх өгүүлэлдээ дархан ван Пунцагцэрэн Банчин богд, Далай ламын хаа заларч байгаа тухай мэдээлэн, түүнтэй холбоо тогтоохыг хүссэн бололтой гэж таамагласан байдаг. Пунцагцэрэн сүжиг бишрэл ихтэй байсныг гэрчилж болох бас нэгэн баримт гэвэл “Галсангийн Навааннамжилын бүтээлийн дээжис” гэх номд Бадаргуулт төрийн хорин нэгдүгээр он (1895)-д Жибзундамба хутагтын түлэгдсэн сүмийг шинэтгэн засах зэрэг үйлд тусалсан учир гурван дэсийн зэрэг

<sup>16</sup> Монгол Улсын Үндэсний Төв Номын Санд хадгалагдаж буй гар бичмэл (хадгаламжийн дугаар нь 1393\96) данс дэвтрийн 14.

<sup>17</sup> Монгол Улсын Үндэсний Төв Номын Санд хадгалагдаж буй гар бичмэл (хадгаламжийн дугаар нь 1393\96) данс дэвтрийн 20.

<sup>18</sup> Монгол Улсын Үндэсний Төв Номын Санд хадгалагдаж буй гар бичмэл (хадгаламжийн дугаар нь 1393\96) данс дэвтрийн 37.

<sup>19</sup> Урангуа, Ж. *Чин гүрний Засагт тус хийх яамны хуралдаанд Монгол ноёд оролцсон нь*, Улаанбаатар- Acta Historica, 2013.

нэмж дэвшүүлсэн гэж байгаагаар нь магадалж болно. Пунцагцэрэн ван хийгээд Богд Жибзундамба хутагтын гэр бүлийн хооронд ч дотно сайхан харьцаатай байсан гэдгийг Пунцагцэрэн вангаас Жибзундамба ба гэргий Дондогдуламтай харилцаж байсан захидлаас мэдэж болно. Иймээс Пунцагцэрэн ван хийгээд Богд Жибзундамба хутагтын хооронд, цаашлан хоёр гэр бүлийн хооронд дотно сайн харилцаа байсан байна.

Пунцагцэрэн вангаас Жибзундамба хутагтад илгээж байсан захидал, мэдээлэл нь Манж Чин гүрний хааны оронд нөхцөл Хятадын байдал, монголын талаар явуулж байгаа бодлого, үйл ажиллагаа зэргийг мэдэж, Монголын тусгаар тогтнолын төлөө тэмцэлд чухал үүрэг гүйцэтгэсэн хэмээн үзэж болно.

### Дүгнэлт

Чин улсын үеийн Их Хүрээ нь Халхын Түшээт хан аймгийн харьяа газарт байршсаны учраас Чингисийн алтан урагтны хойчис болох засаг хошууны дархан чин ван Пунцагцэрэнгийн удам угсаа нь олон үеэр Их Хүрээний Монгол сайдын албан тушаалын ажил үүргийг үүрэглэн гүйцэтгэдэг байжээ.

Тэрээр Чин улсын сүүлч Шинэ засгийн бодлогын Монгол оронд хэрэгжүүлэх болсон тохиолоор Хүрээний монгол сайдын төлөөлөгчийн хувиар Бээжинд ирж, Засагт тус хийх яамны хэлэлцэгч түшмэлийн хувиар хуралд оролцоод, төлөөлөгчөөр ирсэн Ар, Өвөр Монголын ван гүнгийн нийт тооны харьцаа нь дэндүү бага байснаас Чин улсын Засгийн газраас Монгол орны эд агуурс, малын гаралтай баялаг мэтийн зүйлсийг улам их хэмжээгээр цөлбөн дээрэмдэх болсон мөн чанарыг ойлгож ухаарчээ.

Ар Монголын төлөөлөгч Пунцагцэрэн, Доржпалам нар нь Бээжинд байхдаа Халхын ноёд-эфү Наянт болон Ширнэндамдин нартай холбоотой байж, тэдний тус дэмээр Хүрээний шанзудба Бадамдоржийг эргүүлэн албанд нь томилуулах тал дээр амжилттай ажилласан байна.

Пунцагцэрэн ван бурхны шашинд сүжиг бишрэл ихтэй байж, Богд Жибзундамбын үнэнч сүсэгтэн шавь байсан нь илэрхий. Пунцагцэрэн ван хийгээд Богд Жибзундамбын хооронд дотно нягт харилцаа байсан төдийгүй, гэр бүлийн хооронд ч эелдэг сайхан харилцдаг байжээ. Тэр Хүрээний монгол сайдын төлөөлөгчийн хувиар нийслэл Бээжинд ирсний дараа Богд гэгээнтэн ба түүний гэргий Дондогдуламд олон удаа захидал илгээж, Бээжин хотод болж өнгөрсөн мэдээ чимээг алдалгүй дамжуулж байсны хамтаар тухайн үеийн Бээжинд болж байгаа аливаа зүйлд Богдын өмнөөс тагнан цагдах үүргийг гүйцэтгэж, Шинэ

засгийн бодлого Монгол оронд хэрэгжүүлэгдэх нь зайлшгүй болсон гэдгийг маш соргог таньж мэдсэний улмаас өвчнөөр шалтаглаж, эртхэн Монгол нутагтаа буцаж, Чин улсаас тусгаарлан салах арга замыг эрж сүвэгчилсэн байдаг. Тус баримт материал Богд хаант Монгол улсын тусгаар тогтнох урьдач нөхцөлийг хангасан асар их алс хэтийн ач холбогдолтой түүхэн материал гэдгийг үнэлүүштэй.

### **Abstract**

In September 1910, during the “New Policy” period in Qing Dynasty, the “Senior Administration Council” was established in Beijing, and Puntsagtseren was appointed as the representative of the Khuree Ministry. Based on the fact that he repeatedly received letters from Bogd gegeen and his wife Dondogdulam during the council conference in Beijing, the last “New Policy” of the Qing Dynasty was to expand the wealth of Mongolia. He revealed the nature of plunder, saying that the Mongols were looking for a way to separate themselves from the real state.

### **Ашигласан материал**

1. Монгол Улсын Үндэсний Төв Номын Санд хадгалагдаж буй гар бичмэл (хадгаламжийн дугаар 1393/96).
2. *Галсангийн Навааннамжилын бүтээлийн дээжис*, Улаанбаатар, 2011.
3. Ц.Сономдагва, *Монгол Улсын засаг захиргааны зохион байгуулалтын өөрчлөлт шинэчлэлт (1691-1997)*, Улаанбаатар, 1998.
4. Ж.Урангуа, “Чин гүрний Засагт тус хийх яамны хуралдаанд Монгол ноёд оролцсон нь, -- *Acta Historica*, (2013). Улаанбаатар.